



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/249

Булган сум

Нийлүүлэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Аймгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх” нийлүүлэгчээр шалгарсан “Их баянболдог” ХХК -тай 123,880,000 (нэг зуун хорин гурван сая найман зуун наян мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Их баянболдог” ХХК -ны захирал (Б.Энхтуул)-д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж чанар стандарт, жин, хэмжээ, сав, баглаа боодол тоо ширхгийн дагуу хүлээн авч хадгалалт, хуваарилалтад хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Н.Пүрэвсайхан), Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Лхагваням) нарт даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010332

Аймгийн Засаг даргын 2026 оны  
04 дүгээр сарын 08-ны нийгмийн өдрийн  
А.Д.М.С. дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд
3	Бараа нийлүүлэх хуваарь	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 7 хоног	Г.Гантулга Н.Пүрэвсайхан М.Лхагваням

--o00o--